

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан.....	12
4.3 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	13
4.4 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЗАСГИЙН ГАЗРЫН АВТО БААЗ
УТҮГ-ЫН ЗАХИРАЛ С.ЭНХБАЯР
ТАНАА

2020.03.13 № 06/800
танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Засгийн газрын авто бааз УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Засгийн газрын авто бааз УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Засгийн газрын авто бааз УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага


Засгийн газрын авто бааз УТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Засгийн газрын авто бааз УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус байгууллагын захирал С.Энхбаяр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийг холбогдох журам зааврын дагуу хөтлөх талаар өгсөн зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Засгийн газрын авто бааз УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Засгийн газрын авто бааз УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Засгийн газрын авто бааз УТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацаанд санхүүгийн тайлан тодруулгыг СТОУС, НББОУС, болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан нь дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 12 дугаар сарын 12-ноос 2020 оны 3 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Засгийн газрын авто бааз УТҮГ-ын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Нью Эстимэйтор Аудит ХХК-ийн аудитор Ж.Үхэртар хариуцан хэрэгжүүлж, аудиторын туслах Б.Халиунаа, Ү.Алтанзул нар туслах үүрэгтэйгээр оролцов.

Засгийн газрын авто бааз УТҮГ нь 2019 оны санхүүгийн тайланг 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Засгийн газрын авто бааз УТҮГ-ын зорилго нь төр засгийн байгууллагад олон улсын стандартын түвшинд хүрсэн тээврийн нийтлэг үйлчилгээ үзүүлж, хуулиар тогтоосон зорилт чиг үүргээ хэрэгжүүлэх таатай орчин, нөхцөл бүрдүүлэхэд оршино.

Үйл ажиллагааны чиглэл:

Засгийн газрын авто бааз УТҮГ-ын үндсэн үйл ажиллагаа нь төр засгийн байгууллагуудад тээврийн үйлчилгээ үзүүлэх явдал юм.

Засгийн газрын авто бааз УТҮГ-ын удирдлага нь дараах хууль болон СТОУС, НББОУС, түүнд нийцүүлэн баталсан байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого журмын хүрээнд төсөв, санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- ✓ Шилэн дансны тухай хууль
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль
- ✓ Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль
- ✓ Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- ✓ Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус зөвлөлийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Засгийн газрын авто бааз УТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Ноён” санхүүгийн программ хангамжийг ашигладаг байна.

Засгийн газрын авто бааз УТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад тус байгууллага нь дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Засгийн газрын авто бааз УТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 8 чиглэлд 12 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогоор сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3,111.6 сая төгрөгөөс тооцон 31.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын хувь хэмжээг төлөвлөлтийн шатанд тооцсон 1.0 хувиар, суурь үзүүлэлтийг 2019 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогоор сонгож 59.3 сая төгрөгөөр тооцов.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Засгийн газрын авто бааз УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 384.9 сая төгрөгөөр буюу 2.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /сая төгрөг/ 3=2-1
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	885.5	812.1	(73.4)
Авлага	287.9	340.9	53.0
Урьдчилгаа	-	193.4	193.4
Бараа материал	83.9	61.0	(22.9)
Үндсэн хөрөнгө	12,982.9	12,447.8	(535.1)
Биет бус хөрөнгө	718.8	718.8	-
Биологийн хөрөнгө	43.4	43.5	0.1
Нийт хөрөнгө	15,002.4	14,617.5	(384.9)
Өр төлбөр	50.4	19.5	(30.9)
Эздийн өмч	14,952.0	14,598.0	(354.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	15,002.4	14,617.5	(384.9)

Авлага дансны үлдэгдэл өмнөх тайлант жилээс өссөн нь Хүмүүн фильм ТББ-д гэрээгээр ажил үйлчилгээ үзүүлсэний 71.7 сая төгрөгийн авлагын тооцоо үүссэнээс шалтгаалжээ.

Авлагын дансанд бүртгэлтэй 114.1 сая төгрөгийн тээврийн үйлчилгээтэй холбоотой авлагаас он удаан жил болсон 4 харилцагчийн 8.8 сая төгрөгийн, татвар, НДШ-ийн 2.1 сая төгрөгийн, даатгалын нөхөн төлбөрийн 5.3 сая төгрөгийн, шүүхийн шийдвэрийн дагуу хувь хүнээс авах 11.1 сая төгрөгийн, ажиллагсдаас авах 27.0 сая төгрөгийн, 400 автомашины гражийн барилгын засвар үйлчилгээтэй холбоотой Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 181.4 сая төгрөгийн нийт 340.9 сая төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 22.9 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагын дагуу бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг бараа материалын данснаас хассантай холбоотой байна.

Тайлант хугацааны эцэст бараа материалын данс 61.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд 37.9 сая төгрөгийн сэлбэг, 15.7 сая төгрөгийн аж ахуйн, 6.9 сая төгрөгийн хангамжийн материал, 0.5 сая төгрөгийн шатах тослох материал байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант оны элэгдлийн зардлаар хуримтлагдсан элэгдэл өссөнтэй холбоотой байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрийн дагуу тээврийн хэрэгсэл балансаас балансад шилжүүлж 638.8 сая төгрөгөөр нэмэгдэж, 220.4 сая төгрөгөөр хасагдсан байна.

Мөн үндсэн хөрөнгийн дансанд 83.2 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, компьютер дагалдах хэрэгслийн худалдан авалт, 6.3 сая төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан тавилга эд хогшил багтсан байна.

Өр төлбөр данс нь өмнөх тайлант оноос 30.9 сая төгрөгөөр буурсан нь дансны өглөгийг тайлант жилд бүрэн барагдуулсантай холбоотой байна. Өр төлбөр дансны 2019 оны үлдэгдэл 19.5 сая төгрөг нь 3 харилцагч байгууллагын урьдчилж орсон орлогын тооцоо байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 354.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд хуримтлагдсан алдагдал үүссэнээс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгын 40.4 сая төгрөг нь бараа материалын данстай холбоотой өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагын залруулга бичилтээс үүссэн байна.

2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасны дагуу хөрөнгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, удирдлага нь энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасан улсын төсөвт үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх үүргийг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Засгийн газрын авто бааз УТҮГ нь 2019 онд 6,381.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 6,367.2 сая төгрөгийн зардлыг зарцуулж, 13.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллах зорилтот түвшинг баталсан байна. Гүйцэтгэлээр тайлант онд 5,931.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардалд 6,245.2 сая төгрөгийг зарцуулж, 313.6 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Өмнөх оноос орлого 112.1 сая төгрөгөөр, зардал 555.1 сая төгрөгөөр өсөж, ашиг 443.1 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант жилд алдагдалтай ажилласан шалтгаан нь балансаас балансад шилжин ирэх автомашинууд ирээгүйн улмаас үйл ажиллагааны бус орлого төлөвлөсөн дүндээ хүрээгүй бөгөөд 619.9 сая төгрөгөөр дутуу буюу 70.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 2. Орлого зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт төлбөрт гүйлт /мян.км/	2.7	2.8	0.1	102
Үндсэн үйл ажиллагааны	1,687.4	1,859.2	171.8	110
Үйл ажиллагааны бус	2,120.2	1,500.3	-619.9	71
Улсын төсвийн санхүүжилт	2,574.2	2,574.2	-	100
Бусад	-	-2.2	-2.2	
Нийт дүн	6,381.8	5,931.5	-445.7	93
Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны	5,945.0	5,867.8	-77.2	99
Үйл ажиллагааны бус	422.2	361.6	-44.8	89
Нийт дүн	6,367.2	6,229.4	-137.8	98

Татварын өмнөх ашиг/алдагдал	14.6	-297.9	-312.5	
Орлогын татварын зардал	1.4	15.7	-14.2	
Цэвэр ашиг/алдагдал	13.1	-313.6	-326.7	

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 эрсдэлд нийт 16 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 11.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн бөгөөд алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар дугуйнаас бусад сэлбэг хэрэгслийн зарцуулалт, албан томилолтын тооцоог нарийвчилж авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Засгийн газрын авто бааз УТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Тус байгууллага шилэн дансны мэдээллээр цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 111 удаагийн 1,208.7 сая төгрөгийн, зарлагын 115 удаагийн 1,805.5 сая төгрөгийн гүйлгээг тус тус мэдээллэсэн байна. Мөн шилэн дансны мэдээнд тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө зэргийг байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар өгсөн нийт 70.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

Мөн нийт 7.0 сая төгрөгийн зөрчилтэй холбоотой 2 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн 70.0 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Засгийн газрын авто бааз УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Засгийн газрын авто бааз УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант жилийн эцсийн байдлаар тээврийн үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотойгоор үүссэн 6 харилцагчийн 11.8 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

1.2. Эрсдэл:

Авлага барагдахгүй байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

1.3. Өгсөн зөвлөмж:

Тээврийн үйлчилгээтэй холбоотой авлагыг сар бүр хугацаанд барагдуулж, авлагын тооцоотой гарсан тохиолдолд тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

2.1. Илрүүлэлт:

Засгийн газрын авто бааз нь 00-97 УБЯ Toyota Land criuser 200, 00-29 УБЯ Toyota Land criuser 200, 00-52 УБЯ Toyota Land criuser 200, 06-63УНУ HYUNDAI SONATA LF, 03-68УБЗ HYUNDAI SONATA LF гэсэн 5 автомашиныг 2019 оны 3 дугаар сар болон 6 дугаар сард Монгол Хьюндай

автомотив ХХК, Таванбогд ХХК-иас хүлээж авч, ашиглаж байгаа боловч Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас шийдвэр гараагүй тул балансад бүртгээгүй байна.

2.2. Эрсдэл:

Хөрөнгийг данс бүртгэлд тусгахгүй байх, зардлыг илүү/дутуу тооцох, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

2.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэж заасныг мөрдөж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Балансын үзүүлэлт	2018 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгөн хөрөнгө	885,466,410.52	812,062,755.33
1.1.2	Дансны авлага	60,406,615.60	114,094,834.86
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	1,843,502.15	400,768.86
1.1.4	Бусад богино хугацаат авлага	225,696,615.14	226,401,610.37
1.1.6	Бараа материал	83,853,350.34	61,046,052.72
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	193,414,789.02
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,257,266,493.75	1,407,420,811.16
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	12,982,882,803.89	12,447,750,253.94
1.2.2	Биет бус хөрөнгө	718,836,000.00	718,836,000.00
1.2.3	Биологийн хөрөнгө	43,414,999.41	43,503,582.75
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	13,745,133,803.30	13,210,089,836.69
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	15,002,400,297.05	14,617,510,647.85
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.3	Татварын өр	25,455,588.48	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	24,919,254.00	19,500,363.82
	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	50,374,842.48	19,500,363.82
2.2	Өр төлбөрийн нийт дүн	50,374,842.48	19,500,363.82
2.3	ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.3.1	Өмч-төрийн	11,744,520,814.45	11,744,520,814.45
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,132,191,677.04	2,132,191,677.04
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	718,836,000.00	718,836,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг, алдагдал	356,476,963.08	2,461,792.54
2.3.11	Эздийн өмчийн дүн	14,952,025,454.57	14,598,010,284.03
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	15,002,400,297.05	14,617,510,647.85

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,681,505,937.22	1,856,930,004.63
2	Борлуулалтын өртөг	2,290,317,774.84	2,523,472,828.18
3	Нийт ашиг (алдагдал)	(608,811,837.62)	(666,542,823.55)
7	Татаас санхүүжилтийн орлого	2,412,668,900.00	2,574,199,200.00
8	Бусад орлого	1,724,931,342.27	1,500,288,317.09
9	Борлуулалт маркетингийн зардал	3,092,510,468.87	3,297,463,556.99
10	Ерөнхий ба удирдлагын зардал	96,557,600.00	96,654,040.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	327,387.11	137,196.78
17	Бусад ашиг (алдагдал)	(176,571,435.60)	(311,822,853.19)
18	Татвар төлөхийн өмнөх (алдагдал)	163,476,287.28	(297,858,559.86)
19	Орлогын татварын зардал	34,004,772.28	15,738,939.58
20	Татварын дараах ашиг (алдагдал)	129,471,515.00	(313,597,499.44)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	129,471,515.00	(313,597,499.44)
24	Орлогын нийт дүн	129,471,515.00	(313,597,499.44)

4.3 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,622,352,422.48	4,910,677,033.43
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,640,404,119.15	1,727,465,956.85
	Даатгалын нөхвөрөөс хүлээж авсан мөнгө	4,920,733.00	71,962,596.05
	Татаас санхүүжилтийн орлого	2,412,668,900.00	2,574,199,200.00
	Бусад мөнгөн орлого	564,358,670.33	537,049,280.53
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,283,303,920.96	4,900,897,378.62
	Ажилчдад олгосон мөнгө	1,716,308,428.00	1,827,467,839.0
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	522,999,287.30	574,016,039.51
	Түүхий эд материал худалдан авахад төлсөн мөнгө	2,372,930.00	3,137,980.00
	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	336,106,528.10	260,017,139.87
	Түлш, шатахуун тээврийн хэрэгсэлд төлсөн мөнгө	993,563,235.00	1,111,430,818.00
	Татварын байгууллагад төлсөн мөнгө	214,998,119.84	220,787,327.06
	Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	1,388,000.00	114,307.20
	Бусад мөнгөн зарлага	495,567,392.72	903,925,927.98
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	339,048,501.52	9,779,654.81
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
	Мөнгөн зарлагын дүн (-)	161,544,580.00	83,183,310.00
2.2	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд	161,544,580.00	83,183,310.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(161,544,580.00)	(83,183,310.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	177,503,921.52	(73,403,655.19)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	707,962,489.00	885,466,410.52
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	885,466,410.52	812,062,755.33

4.4 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ний өдөр	11,744,520,814.45			227,005,445.08	11,971,526,262.53
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал				129,471,515.00	129,471,515.00
Бусад дэлгэрэнгүй орлого		2,132,191,677.04	718,836,000.00		2,851,027,677.04
2018 оны 12-р сарын 31-ний өдөр	11,744,520,814.45	2,132,191,677.04	718,836,000.00	356,476,963.08	14,952,025,454.57
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				(40,417,671.10)	(40,417,671.10)
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал				(313,597,499.44)	(313,597,499.44)
2019 оны 12-р сарын 31-ний өдөр	11,744,520,814.45	2,132,191,677.04	718,836,000.00	2,461,792.54	14,598,010,284.03

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020.03.10	Аудитын нэр:	Засгийн газрын авто бааз УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
Шалгагдсан байгууллагын нэр:	Засгийн газрын авто бааз УТҮГ			САГ-2020/66/СТА-ТӨҮГ
				сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1		2	3	4	5
1	2019 оны жилийн эцсийн байдлаар 21 байгууллага, 2 хувь хүнтэй холбоотой нийт 114.1 сая төгрөгийн тээврийн үйлчилгээтэй холбоотой авлагын үлдэгдэл байгаа бөгөөд үүнээс 22 харилцагчийн 102.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, 6 харилцагчийн 11.8 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	11.8	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч	А.Буян-Ундрах
2	Засгийн газрын авто бааз нь 00-97 УБЯ Toyota Land cruiser 200, 00-29 УБЯ Toyota Land cruiser 200, 00-52 УБЯ Toyota Land cruiser 200, 06-63УНУ HYUNDAI SONATA LF, 03-68УБ3 HYUNDAI SONATA LF гэсэн 5 автомашиныг 2019 оны 3 дугаар сар болон 6 дугаар сард Монгол Хьюндай автомотив ХХК, Таванбогд ХХК-иас хүлээж авч, ашиглаж байгаа боловч Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас шийдвэр гараагүй тул балансд бүртгээгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Захирал, Ерөнхий нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч	С.Энхбаяр, А.Буян-Ундрах
	Дүн	11.8			